




## Нас гүйцсэн эр хонины үнэ Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 266.7 мянган төгрөг байна


Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 8 дугаар сард ат 1.3 сая төгрөг болж, өмнөх сараас 39.6 мянган төгрөгөөр, хязаалан гунын үнэ 1.2 сая төгрөг болж өмнөх сараас 53.7 мянган төгрөгөөр, соёолон үрээний үнэ 1.0 сая төгрөг болж, өмнөх сараас 12.7 мянган төгрөгөөр тус тус өссөн байна. Харин эр хонины үнэ 212.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.2 мянган төгрөгөөр, эр ямааны үнэ 143.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 400 төгрөгөөр тус тус буурсан байна.

ЗУРАГ 1. НАС ГҮЙЦСЭН МАЛЫН ДУНДАЖ ҮНЭ (сум), 2021 оны 8 дугаар сард, мянган төгрөгөөр




Малын зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 8 дугаар сард эр хонь Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 266.7 мянган төгрөг болж, өмнөх сараас 7.5 мянган төгрөгөөр, Дорнод аймагт хамгийн бага буюу 154.3 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.1 мянган төгрөгөөр тус тус өссөн байна.

Зураг 2. Нас гүйцсэн эр хонины дундаж үнэ, 2021 оны 8 дугаар сард, мянган төгрөгөөр




Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 8 дугаар сард цагаан ноолуурын 1кг-ын дундаж үнэ Өвөрхангай, Баянхонгор, Баян-Өлгий аймагт хамгийн их буюу 115.0 мянган төгрөг, Булган аймагт хамгийн бага буюу 50.0 мянган төгрөг байна.

ЗУРАГ 2. ЦАГААН НОЛУУРЫН 1 КГ-ЫН ДУНДАЖ ҮНЭ, 2021 оны 8 дугаар сард, төгрөгөөр



Мал аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 8 дугаар сард үхрийн 2 метрээс дээш урттай шир 8.9 мянган төгрөг болж, өмнөх сараас 2.2 мянган төгрөгөөр өссөн, ямааны цагаан ноолуур 1 кг-ын үнэ 99.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 3.1 төгрөгөөр буурсан байна.

ЗУРАГ 3. МАЛ АЖ АХУЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ЗАХ ЗЭЭЛИЙН ДУНДАЖ ҮНЭ, жил бүрийн 8 дугаар сард, төгрөг



Газар тариалангийн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээллээр 2021 оны 8 дугаар сард 25кг хивэгний үнэ Дорноговь аймагт хамгийн их буюу 24.4 мянган төгрөг болж, өмнөх сараас 1.9 мянган төгрөгөөр өссөн, Архангай аймагт хамгийн бага буюу 12.5 мянган төгрөг болж, өмнөх сараас өөрчлөлтгүй байна.

### Тооцох аргачлал

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн судалгааг сар бүр, сум, дүүрэг, аймаг, нийслэлийн худалдааны цэгүүдээс авч нэгтгэн сарын дундаж үнийг арифметик дунджаар тооцно.



Эх үүсвэр: ҮСХ, ХАА-н бүтээгдэхүүний зах зээлийн дундаж үнийн мэдээ

### Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>  
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ гархаах хуваарь: 2021 оны 10 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас : (976-11)-329272

Эдийн засгийн статистикийн газрын  
гэрээт ажилтан Б. Оргил  
Утас : (976-51)-261563



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212